



ХӨВСГӨЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 07

Мөрөн

Орон нутгийн чанартай авто зам,
замын байгууламж ашигласны төлбөрийн
хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2"д", Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн чанартай болон авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журмыг хуулийн дагуу баталж, орон нутагтаа мөрдөн ажиллахыг аймгийн Засаг дарга (Л.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. Батлагдсан тогтоолын холбогдох материалын бүрдүүлбэрийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д даалгасугай.

4. Тус тогтоолыг "Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл"-д нийтэлсний дараа мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга (Л.Ганболд)-д даалгасугай


5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчид, Төсөв, санхүү, эдийн засгийн хороо, Хот байгуулалт, дэд бүтцийн хороонд даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын ээлжит IX хуралдааны
2018 оны 12 дугаар сарын 5-ны
өдрийн 7 дугаар тогтоолын
хавсралт



ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТОЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ,
АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	/төгрөг/	
		Орон нутагт бүртгэлтэй тээврийн хэрэгслээс жилд 1 удаа	Орон нутагт бүртгэлгүй авто машинаас зорчсон тухай бүр
1	2 дугуйтай мотоцикл	2,000	
2	3 дугуйтай мотоцикл		
3	Суудлын автомашин:	10,000	1,000
4	Микро автобус /15 хүртэл суудалтай/	10,000	2,000
5	Автобус	15,000	5,000
6	Ачааны автомашин:		
	Үүнээс:	1-5 хүртэл тн-ын даацтай	1,000
		5-20 хүртэл тн-ын даацтай	5,000
		20-дээш тн-ын даацтай	20,000
7	Тусгай зориулалтын автомашин	10,000	3,000
8	Трактор, өөрөө явагч бусад хэрэгслэл		
9	Бага оврын трактор		
10	Чиргүүл /даацын 1 тн тутамд/	1,000	1,000